



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар A/198

Улаанбаатар хот

**Г Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл хүчингүй болгох тухай Г**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Нийслэлийн Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр шийтгэх тогтоол, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 3 дугаар сарын 20-ны 4/7049 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний их эмч Батсүхийн Эрдэнэзулд олгосон ИЭ0019308 сери, 0019308 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс гурван жилийн хугацаагаар хүчингүй болгосугай.

2. Б.Эрдэнэзулын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр ажиллах эрх үүстэл буюу 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Л.Ганболд/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Монголын хувийн хэвшилийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо /Ч.Доржгүнсмаа/, Грандмед эмнэлэг /Н.Гансүх/, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /Р.Энхтайван/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



080767